



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬ

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ – 2018

Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

- 2019 оны 01 дүгээр сарын 24-25-ны өдөр
- ШУА-ийн Нэгдсэн I байрны 410 тоот хурлын танхим
Улаанбаатарын Их Сургуулийн хурлын танхим

Зохион байгуулагч:

Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхим
ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн

Оролцогч байгууллагууд:

МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхим
Монголын Үндэсний Музей
ШУТИС-ийн БУХС-ийн Хүмүүнлэгийн салбар
Нүүдлийн Соёл Иргэншлийг судлах олон улсын хүрээлэн
Соёлын Өвийн Үндэсний Төв
Ховд Их Сургууль

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ-2018 ОН

Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

Ерөнхий редоктор: Д.Эрдэнэбаатар
Эрхлэн нийтлүүлсэн: Ч.Амартүвшин
Ж.Эрдэнэ
Хэвлэлд бэлтгэсэн: Ж.Эрдэнэ
Д.Цэнд

Цаасны хэмжээ: 176x250 мм
Хэвлэлийн хуудас: 32.3 х.х
Хэвлэсэн тоо: 300 ш

“Бемби сан” хэвлэх үйлдвэрт хэвлэв.



ГАРЧИГ

- 1 Б.Гүнчинсүрэн, Д.Базаргүр, А.М. Хаценович, Е.П. Рыбин, Д.В. Олсен, Д.В. Марченко, С.А. Когай, А.С. Кравцова, Р.А. Шелепаев, А.Ю. Попов, Я.Ю. Шелепов, Т.А. Шевченко. Орхоны хөндийн чулуун зэвсгийн дурсгалуудад хийсэн судалгаа – 2018. (Орхон -1, Мойлтын ам) 9
- 2 Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Г.Лхүндэв, Д.Одсүрэн, Г.Ангарагдөлгөөн, Н.Звинс, М.Изухо, К.Пэйн. Төлбөр-17 палеолитын дурсгалт газарт 2018 онд хийсэн малтлага судалгааны тухай 15
- 3 Д.Базаргүр, Г.Лхүндэв, Албан Дефлиор. Горхи-Тэрэлжийн сав газарт хийсэн археологийн мэдээ шалгах, тандалт судалгаа: Агуйт хадны чулуун зэвсгийн дурсгалын малтлага 22
- 4 Д.Одсүрэн, Л.Яанз, Д.Бөхчулуун. Монгол-Канадын хамтарсан “Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа” төслийн 2018 оны хээрийн шинжилгээний ажлын тухай 27
- 5 Я.Цэрэндагва, Ж.Фаркухар, С.Далантай, Р.Төрбат, Х.Элскен. Их нартын чулуунд ажилласан Монгол-Америкийн хамтарсан экспедицийн 2018 оны хээрийн шинжилгээний ажлын товч үр дүн 35
- 6 Ч.Амартүшин, У.Ханичёрч, З.Батсайхан, У.Эрдэнэбат, Ж.Врайт, Ш.Гидеон, Д.Одсүрэн, Г.Галдан, Б.Батдалай, Б.Бөхчулуун, Д.Мандах, О.Батзориг, А.Камерон, А.Орхонсэлэнгэ, С.Плэутэр, В.Вилсон, Ц.Цэлхагарав, М.Алтаншагай, С.Рамшлэг, Ж.Фэнг. Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол: археологийн хайгуул судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2018 оны судалгааны товч үр дүн 41
- 7 Ж.Баярсайхан, Жан-Лүүк Хюл, Оула Сейцонин, Ч.Баяндэлгэр, Наталья Эгүз. Монгол-Америкийн хамтарсан “Баруун Монгол” төслийн 2018 оны хээрийн судалгааны товч үр дүн 49
- 8 Ю.Болдбаатар, Д.Хатанбаатар, С.Бат-Эрдэнэ, Г.Очирболд. ШУТИС-ийн БУХС-ийн археологи угсаатны зүйн судалгааны багийн Баянхонгор аймгийн Баян-овоо, Өлзийт, Жинст сумдад явуулсан хайгуул судалгаа 53
- 9 Т.Идэрхангай, Д.Цэнд, Б.Амгаланбат, Б.Батчимэг. Өмнөговь аймгийн Сэврэй сумын нутаг дахь Салхит ууланд явуулсан хадны зургийн судалгаа 56
- 10 З.Батсайхан, С.Тэргүүнбаяр, Ч.Амарбилиг, Д.Содномжамц, Б.Дашзэвэг. Монгол-Хятадын хамтарсан “Монгол нутаг дахь археологийн малтлага судалгаа” төслийн хүрээнд Чулуун онгоцот, Тахилга уулын хадны зургийн судалгааны урьдчилсан үр дүн 61
- 11 Ю.Болдбаатар, Д.Хатанбаатар, Ц.Бямба-Очир, С.Бат-Эрдэнэ Булган аймгийн Тэшиг сумын Харгал нуурын орчимд хийсэн хадны зосон зургийн хайгуул судалгаа 64
- 12 З.Батсайхан, Ч.Амарбилиг, Д.Содномжамц, С.Тэргүүнбаяр, Пан Лин, Ван Лисин, Далаандөрөв. Монгол-Хятадын хамтарсан “Түйн гол” археологийн хээрийн шинжилгээний ангийн 2018 оны хайгуул, малтлага судалгааны ажлын товч үр дүн 66
- 13 Ч.Мөнхбаяр, А.А.Ковалев, Ц.Буян-Орших, Д.Сүхбаатар. Монгол-Оросын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутаг Их хулагаш, Ямаатын голын археологийн дурсгалын судалгаа 70
- 14 Ж.Гантулга, Ч.Ерөөл-Эрдэнэ, У. Бросседер. Монгол-Германы хамтарсан “Баркор” төслийн 2018 оны хээрийн судалгааны ажлын товч үр дүн 87



15	Ж.Гантулга, Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Магай. Монгол-Монакогийн хамтарсан “Хойд Тамир-Хүнүй” төслийн 2018 оны хээрийн судалгааны ажлын товч үр дүн	91
16	Д.Эрдэнэбаатар, Э.Мижиддорж, Б.Галбадрах, Ж.Эрдэнэ, Жоу Ли Ган, Лю Бин, Ни Фен, Рей Шан. Монгол-Хятадын хамтарсан “Хүрэл-төмрийн үеийн нүүдэлчдийн археологийн дурсгал” төслийн 2018 оны Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Хануй багийн нутагт ажилласан археологийн малтлага судалгаа	94
17	З.Батсайхан, Ч.Амартүвшин, Д.Содномжамц, Б.Батдалай, Б.Батзориг. Төв аймгийн Лүн сумын Оорцог ууланд хийсэн археологийн судалгааны товч үр дүн	99
18	Б.Анхбаяр, Ц.Амгалантөгс, Ц.Болорбат, Г.Батболд, Цао Жиан эн, Сүн Гүо дүн. Монгол улс, БНХАУ-ын хамтарсан археологийн судалгааны 2018 оны ажлын товч үр дүн (Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт хийсэн археологийн судалгаа)	103
19	Г.Эрэгзэн, С.Энхболд, П.Алдармөнх, У Жэ жин, Ан Жэ пил. Төв аймгийн Баянцагаан сумын нутагт ажилласан Монгол-Солонгосын хамтарсан ангийн археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын үр дүнгээс	111
20	Ц.Мөнхбат, Ч.Энхтөр. Ховд аймгийн нутгаас 2018 онд шинээр илэрсэн хадны зураг дахь тэрэгний дүрслэлүүд	117
21	Н.Батболд, Д.Батсүх, Н.Баярхүү, Б.Өмирбек, Жон Сон Муг. Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн 2018 оны судалгааны үр дүн	123
22	Ю.Болдбаатар, Г.Анхсанаа, Д.Хатанбаатар. Богд хан уул орчимд хийсэн хайгуул судалгаа	129
23	Г.Анхсанаа, Д.Нямдорж, П.Чинбат, А.Мөнгөнцөөж. Соёлын өвийн үндэсний төвөөс Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор дурсгалд ажилласан хээрийн судалгаа	134
24	Монгол-Оросын хамтарсан “Төв азийн археологийн шинжилгээ-1” төслийн Хөвсгөл аймгийн Ханх сумын нутагт явуулсан малтлага судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээс	140
25	Ч.Амартүвшин, Л.Эрдэнэболд, Б.А.Биликто, М.А.Денис, Д.Хатанбаатар, Р.Төгссайхан, Б.Батдалай. ОХУ-ын Улаан-Үүд хотын орчимд буй хүрэл зэвсгийн үеийн археологийн дурсгалуудтай танилцсан тухай	147
26	Т.Идэрхангай, С.Оргилбаяр, А.А.Гишкин, Н.Н.Серегин, Д.Цэнд, Б.Батчимэг, Б.Амгаланбат, П.Эрдэнэпүрэв. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын хөндийд явуулсан археологийн малтлага судалгаа	150
27	Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Л.Ишцэрэн, Г.Галдан, Ц.Цэлхагарав, Т.Сасада, И.Үсүки, Т.Сагава, Х.Үчида, Т.Шёожи, Т.Янагимото, Д.Накамүра. Монгол-Японы хамтарсан “Эртний монголчуудын үйлдвэрлэлийн түүх” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2018 оны товч үр дүн	156
28	Д.Эрдэнэбаатар, Э.Мижиддорж, Б.Галбадрах, Ж.Эрдэнэ. Улаанбаатарын их сургуулийн Археологийн тэнхимийн суурь судалгааны төслийн 2018 оны үр дүнгээс	161
29	Г.Эрэгзэн, П.Алдармөнх, С.Энхболд, А.Амарболд, Ц. Эгиймаа, Жан Өнжон, И На гён. Мон-Сол төслийн хүрээнд Дуурлиг нарсны дурсгалт газарт 2018 онд хийсэн судалгааны үр дүнгээс	166



- 30 Г.Эрэгзэн, С.Энхболд, П.Алдармөнх. “Хүннүгийн хот суурин, үйлдвэрлэлийн түүхийн судалгаа” суурь судалгааны төслийн хүрээнд 2018 онд явуулсан археологийн хээрийн судалгааны ажлын үр дүнгээс 171
- 31 Ц.Одбаатар, Б.Амгаланбат, И.Будбаяр. “Монгол-Хятад”-ын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн Төв аймгийн Цээл сумын Шийгэрт явуулсан археологийн судалгааны танилцуулга 178
- 32 Л.Эрдэнэболд, Ч.Ванчигдаш, З.Одбаяр. Бишрэлтийн амны хүннүгийн жирийн иргэдийн оршуулгын бүлэг дурсгалд 2018 онд хийсэн археологийн малтлага судалгааны урьдчилсан үр дүнгээс 184
- 33 Ж.Цамбагарав, А.Энхтөр, Л.Шинэбат, Т.Батбаяр, Л.Мөнхбаяр, Б.Дэжидмаа, Г.Батболд. Хархорин сумын нутагт дахь Дунд булгийн амны хүннүгийн булшны малтлага судалгаа 189
- 34 А.Очир, С.Хүрэлсүх, Г.Мандахбаяр, Чен Ён Жи, Саранбилэг, Чэн ПенФей. Монгол-Хятадын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн Архангай аймгийн Өгийнуур сумын Талын гурван хэрэмд 2018 онд малтсан судалгааны ажлын товч үр дүн 195
- 35 Ч.Амартүвшин, Я.Мүраками, Л.Ишцэрэн, Г.Галдан, Н.Амитан, Ж.Брайс, Ж.Жонхө. Алтайн бүс нутагт ажилласан Монгол-Японы хамтарсан төслийн урьдчилсан үр дүнгээс 207
- 36 Л.Ишцэрэн, К.Кияма, Т.Саада, М.Сагава, Т.Осава, Л.Мөнхбаяр, Ц.Амгалантөгс, Б.Эрдэнэ. Монгол-Японы хамтарсан хээрийн шинжилгээний ангийн Улз голын хөндийд хийсэн археологийн хайгуул, малтлага судалгааны урьдчилсан үр дүнгээс 214
- 37 Ц.Одбаатар, Б.Даваацэрэн, М.Нямбат, М.Барс, Г.Энхбаяр “Монгол-Хятадын хамтарсан Айрагийн гозгор дахь эртний нүүдэлчдийн археологийн судалгаа” төслийн 2018 оны хээрийн судалгааны ажлын товч үр дүн 221
- 38 С.Өлзийбаяр, Б.Батсүрэн, Б.Очир, Э.Уртнасан. “Хүннүгийн дараах нүүдэлчид - 2018” хээрийн судалгааны урьдчилсан үр дүнгээс 227
- 39 Т.Идэрхангай, А.А.Тишкин, В.В.Горбунов, Н.Н.Серегин, Б.Өнөрбаяр, Д.Цэнд, Б.Батчимэг, П.Эрдэнэпүрэв. Монгол-Оросын хамтарсан “Төв Азийн археологийн шинжилгээ-2” хээрийн шинжилгээний ангийн Баян-Өлгий аймгийн Алтай сумын нутагт ажилласан малтлага судалгааны ажлын үр дүнгээс 231
- 40 Ц.Одбаатар, Ц.Эгиймаа, Ч.Баяндэлгэр, Акедил Тойшанулы, Олжас Шариязданов. Хаяа худаг, Гүн бүрд дэх түрэгийн тахилын онгонд хийсэн археологийн малтлага судалгаа 237
- 41 А.Энхтөр, Д.Цэвээндорж, С.Далантай, Ц.Буянхишиг, Д.Кыдырали, Б.Напил, Н.Бөгөнбаев. Олон улсын хамтарсан “Шивээт улаан” төслийн 2018 оны хээрийн шинжилгээний ажлын үр дүн 242
- 42 А.Энхтөр, Р.Мөнхтулга, С.Далантай, Ц.Буянхишиг, Д.Кыдырәлі, Н.Базылхан, Н.Бөгөнбаев. 2018 онд Хөшөө Цайдамд Монгол-Казахстаны хамтарсан хээрийн шинжилгээний ангийн гүйцэтгэсэн археологийн судалгааны ажлын урьдчилсан үр дүн 247
- 43 Ю.Болдбаатар, Л.Эрдэнэболд, Д.Хатанбаатар, Г.Анхсанаа, З.Одбаяр. Төв аймгийн Баян-Өнжүүд сумын нутаг, Улхын буланд ажилласан археологийн судалгааны ажлын товч тайлан 250
- 44 У.Эрдэнэбат, К.Франкен, Т.Батбаяр, Х.Рооланд. Уйгурын нийслэл Хар балгасанд 2018 онд Монгол-Германы Орхон экспедицийн хийсэн малтлага судалгаа 254



БУЛГАН АЙМГИЙН ХУТАГ-ӨНДӨР СУМЫН НУТАГ ЭГИЙН ГОЛЫН ХӨНДИЙД ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА СУДАЛГАА

Т.Идэрхангай, С.Оргилбаяр, А.А.Тишкин, Н.Н.Серегин,
Д.Цэнд, Б.Батчимэг, Б.Амгаланбат, П.Эрдэнэпүрэв

Удиртгал

Улаанбаатарын Их сургуулийн (УБИС) Археологийн тэнхимийн хээрийн судалгааны баг нь 2014, 2015 онд археологийн судалгаа явуулдаг бусад дөрвөн байгууллагын хамт Эгийн голын Усан цахилгаан станцын усан сан болон Эрдэнэт-Эг, Сэлэнгийн бэлчир чиглэлийн авто зам, өндөр хүчдэлийн шугамын авран хамгаалах малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэж байсан билээ. Энэ ажлын явцад Эрдэнэт-Эг, Сэлэнгийн бэлчир чиглэлийн авто замын дагуу 9 дурсгал, Эгийн голын усан цахилгаан станцын усан сангийн талбай орчимд 112 дурсгал буюу нийт 121 дурсгалын авран хамгаалах малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэжээ¹.

Тус судалгааны баг 2015 онд Эгийн голын баруун эрэг, Хантай багийн хойд талд, Дамиран уулаас зүүн тийш үргэлжилсэн, зүүн хойд талаараа эгц цавчим хад бүхий Марзын хөтлийн дээр 1-055-1², Эгийн голын зүүн эрэг, Моностойн нурууны урд үзүүр, Харуулын гозгорын уулын өвөр бэлд 1-116³, 1-117⁴ болон 1-117-1⁵ дугаартай Шинэ чулуун зэвсгийн үеийн 4 оршуулгын дурсгалыг малтан судалсан нь Монголын археологийн судалгааны нэн шинэлэг хэрэглэгдэхүүн болсон төдийгүй Монголын археологийн судалгаанд 50 орчим жил орхигдон бүдгэрээд байсан судалгааг дахин сэргээсэн маш чухал ач холбогдолтой судалгааны ажил болсон ба судалгааны үр дүнд хэд хэдэн өгүүлэл, илтгэл хэвлүүлээд⁶ байна.

Монгол орны Шинэ чулуун зэвсгийн үеийн оршуулгын дурсгалыг судлах ажил 1967-1972 оныг хүртэл 5 жил үргэлжилсэн бөгөөд энэ хугацаанд

¹ Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С., Галбадрах Б., Эрдэнэ Ж., Өнөрбаяр Б., Энхмагнай Г. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын усан цахилгаан станцын усан сангийн талбайд явуулсан археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлын 2015 оны тайлан. УБ., 2015, тал 456

² Мөн тэнд, тал 205-212

³ Мөн тэнд, тал 377-379

⁴ Мөн тэнд, тал 384-388

⁵ Мөн тэнд, тал 389-392

⁶ Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С., Галбадрах Б., Эрдэнэбаатар Д., Өнөрбаяр Б. Эгийн голын шинэ чулуун зэвсгийн булшнууд. // *Journal of the Archaeology, History and Culture. Journal of Ulaanbaatar State University*. Vol. 11 (10). Ulaanbaatar, 2015. Pp. 5-22; Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С., Галбадрах Б., Эрдэнэбаатар Д., Өнөрбаяр Б. Умард Монголоос шинээр илэрсэн шинэ чулуун зэвсгийн үеийн оршуулгын судалгаа. // *Древние культуры Монголии, Байкальской Сибири и Северного Китая: Материалы VII Международной научной конференции, Красноярск, 3-7 октября 2016 г, Том 1, стр 126-144*; Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С. Монгол орны шинэ чулуун зэвсгийн үеийн оршуулгын дурсгалын судалгаа, он цагийн асуудал. // *Ази Судлал, (Олон улсын эрдэм шинжилгээний гуравдугаар хурал), Vol. III, Улаанбаатар, 2017, т. 532-542*; Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С. Умард Монголын шинэ чулуун зэвсгийн үеийн оршуулгын дурсгалын он цагийн асуудал. // *Природные условия, история и культура западной Монголии и сопредельных регионов. Материалы XIII Международной научной конференции. Барнаул-Ховд, 2018. Т.204-208*



манай орны дорнод бүс нутгаас шинэ чулуун зэвсгийн үед холбогдох таван оршуулгын дурсгалыг илрүүлэн олж судалсан байдаг⁷. Мөн 2014 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эртний түүх судлалын тасгийн судлаачид Булган аймгийн Эгийн голын Усан цахилгаан станцын авран хамгаалах малтлага судалгааны ажлын явцад Эгийн голын зүүн талаас цутгах Бөгсийн голын хойд талын Бурхан толгойн Элст хөтөлд EGL-TX-57 дугаартай нэгэн булшийг малтан судалж судалгааны ажлын тайландаа дурсгалын төрөлд хоосон булш, он цаг тодорхойгүй хэмээн бичиж тэмдэглэсэн байдаг⁸ нь Шинэ чулуун зэвсгийн үед холбогдоно.

Өнөөдрийн байдлаар Монгол улсын хэмжээнд Шинэ чулуун зэвсгийн үед холбогдох нийт 10 булш оршуулгын дурсгал илэрч олдсоны 5 нь Умард Монголын нутаг, Эгийн голын сав дагуу байрлаж байгаа нь сонирхол ихээхэн татаж байна.

Бид 2014-2015 онуудад Эгийн голын усан цахилгаан станцын усан сангийн талбайд орж устах аюултай далайн түвшинөөс 915 м-ээс доош өндөрт байгаа төлөвлөгөөт дурсгалыг малтан судлаад судалгааны ажлын хугацаа дууссан билээ. Гэвч биднийг Марзын хөтөл, Харуулын гозгор уулын орчимд Шинэ чулуун зэвсгийн 4 оршуулгын дурсгалыг малтан судалж байхад ялангуяа Харуулын гозгор уулын 3 булшны ойр орчмоор булш байж болзошгүй жижиг чулуун дараас мэт зүйл сайтар ажиглавал байсан юм. Учир иймд манай судалгааны баг 2018 оны зун Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн оюутны зуны дадлагын ажлын хүрээнд Эгийн голын зүүн эрэг Харуулын гозгор уул, Бөгсийн голын баруун Элст хөтөл зэрэг газарт энэ төрлийн булш оршуулга байгаа эсэхийг тодруулах зорилго тавин ажилласан болно.

Судалгааны багийн бүрэлдэхүүнд хээрийн шинжилгээний ангийн удирдагчаар Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн багш, археологич, доктор /Ph.D/, дэд профессор Т.Идэрхангай, эрдэм шинжилгээний ажилтнаар тус сургуулийн Археологийн тэнхимийн багш, археологич С.Оргилбаяр, туслах эрдэм шинжилгээний ажилтнаар Д.Цэнд, Б.Батчимэг, Б.Амгаланбат, П.Эрдэнэпүрэв нар болон Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн 9 оюутны хамт нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй баг 2018 оны 6-р сарын 4-24 хүртэлх 21 хоногийн хугацаанд Эгийн голын хөндийд байрлан ажиллав. Малтлага ажлын явцад ОХУ-ын Барнаул хотын Алтайн Улсын Их сургуулийн Археологи, Угсаатан зүй, Музей судлалын тэнхимийн эрхлэгч, археологич, доктор /Sc.D/, профессор А.А.Тишкин, тус сургуулийн багш, археологич, доктор /Ph.D/ Н.Н.Серегин нар хүрэлцэн ирж малтлагын ажилтай танилцаж, зөвлөгөө өгч туршлага солилцсон билээ.

Уг судалгааны ажлын хүрээнд Эгийн голын зүүн талд орших Харуулын гозгор ууланд хүрлийн үеийн булш 1, жижиг тахилын байгууламж

⁷ Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С. Монгол орны шинэ чулуун зэвсгийн үеийн оршуулгын дурсгалын судалгаа, он цагийн асуудал. // Ази Судлал, (Олон улсын эрдэм шинжилгээний гуравдугаар хурал), Vol. III, Улаанбаатар, 2017, т. 533-534

⁸ Өлзийбаяр С., Уртнасан Э., Очир Б., Одмагнай Г., Энхтуул Ч. "Эгийн голын түүх, археологийн дурсгалуудыг авран хамгаалах судалгаа" төслийн тайлан. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн ГБСХ, УБ., 2014, тал 149-150



9, Их хөтөлд Монгол гүрний үеийн булш 3, тахилын байгууламж 1, Бурхан толгойд Түрэгийн үеийн булш 2, Элст хөтөлд Монгол гүрний үеийн булш 2, нийт 18 дурсгалыг⁹ малтан судалсан болно.

Харуулын гозгор уулын малтлага судалгаа

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Хантай багийн төвөөс зүүн урагш 3 км орчим зайд, Эгийн голын зүүн эрэгт, Моностойн нурууны зүүн урд талын шувтрага үзүүрийн өндөр уулыг Харуулын гозгор хэмээн нутгийн иргэд нэрлэдэг ажээ. Уг уулын өвөр энгэрт түүхийн олон үед хамаарах дурсгалууд оршдог бөгөөд энд Эгийн голын усан цахилгаан станцын авран хамгаалах малтлага судалгааны ажлын хүрээнд Улаанбаатарын Их сургуулийн судалгааны баг 2014 онд 1-110 дугаартай Түрэгийн үеийн зэрэгцээ дөрвөн тахилын онгон¹⁰, 2015 онд 1-110 дугаартай тахилын онгонуудын урд талд 1-113 дугаартай Мөнххайрханы соёлын булш, 1-116, 1-117, 1-117-1 дугаартай Шинэ чулуун зэвсгийн үеийн булшнууд, 1-116-1 дугаартай Түрэгийн үеийн булш¹¹-ийг тус тус малтан судалсан болно. Харин 2018 оны зун бид энэ орчимд Шинэ чулуун зэвсгийн үед холбогдох дурсгал байж болох магадлалтай 1-113-1 дурсгалын баруун урд талд 1 дурсгал, 1-116 болон 1-116-1 дурсгалуудын ойролцоо 5 дурсгал, 1-117, 1-117-1 дурсгалуудын ойролцоо 4 дурсгалыг (1-113-1, 1-116-2, 1-116-3, 1-116-4, 1-116-5, 1-116-6, 1-117-2, 1-117-3, 1-117-4, 1-117-5) тус тус сонгон 2014, 2015 онд малтан судалсан дурсгалын ойролцоо байсан учир тухайн дурсгалын дугаарыг үргэлжлүүлэн өгөх байдлаар малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

Дээрх дурсгалуудаас 1-113-1 дугаар бүхий дурсгал нь Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш байсан бөгөөд уг булш нь хөндөгдөж тоногдоогүй, хонины толгой болон адууны толгой, аман хүзүү, шийр бүхий тахилга дагалдуулсан хүний оршуулга илэрсэн нь сонирхолтой. Уг булшны оршуулгын хэсгээс хүний бүтэн яс гарсан бөгөөд олдвор хэрэглэгдэхүүний хувьд бог малын далны яснаас өөр зүйл илэрсэнгүй. Харин Харуулын гозгорт малтсан бусад дурсгалууд нь бүгд тахилга тайлгын зориулалттай чулуун байгууламжууд байсан ба ямар нэгэн эд өлгийн зүйлс гараагүй болно.

Түрэгийн үеийн дурсгалууд

Бид Бөгсийн голын баруун хөндийд орших Бурхан толгой уулын баруун урд энгэрт байх хоорондоо ялимгүй зайтай, баруун хойш чиглэсэн цувраа байдалтай, 3,6-4 м голч бүхий цөөн хэдэн сийрэг чулуун дараастай 2 булшийг Шинэ чулуун зэвсгийн үеийн булш байж магадгүй хэмээн таамаглан малтан судлахад эрт, дундад зууны Түрэг, Уйгурын үед холбогдох нь илэрхий болсон юм. Энэхүү 2 булшийг зүүн урд талаас нь эхлэн УБ-01, УБ-02 хэмээн тус тус

⁹ Т.Идэрхангай, С.Оргилбаяр, А.А.Тишкин, Н.Н.Серегин, Д.Цэнд, Б.Батчимэг, Б.Амгаланбат, П.Эрдэнэпүрэв. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын хөндийд орших Харуулын гозгор, Их хөтөл, Бурхан толгой, Элст хөтөлд явуулсан археологийн малтлага судалгааны ажлын 2018 оны тайлан. УБИС-ийн ГБСХ, Улаанбаатар, 2018.

¹⁰ Идэрхангай Т., Эрдэнэ М., Мижиддорж Э., Оргилбаяр С., Маратхаан А., Галбадрах Б. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын усан цахилгаан станцын талбай, авто замын трассын дагуу явуулсан археологийн малтлага судалгааны ажлын 2014 оны тайлан. УБ., 2014, тал 256-262

¹¹ Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С., Галбадрах Б., Эрдэнэ Ж., Өнөрбаяр Б., Энхмагнай Г. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын усан цахилгаан станцын усан сангийн талбайд явуулсан археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлын 2015 оны тайлан. УБ., 2015, тал 370-392



дугаарлаж малтан судаллаа. Маллагын явцад УБ-01 дугаартай булшнаас хүний яс, төмөр сумын зэв 1, бүтэн ваар 1, бог малын нурууны яс зэрэг олдворууд илэрсэн бол УБ-02 дугаартай булшнаас хүний яс, төмөр дөрөө, төмөр хутга, хүрэл чимэглэлүүд, төмөр эдлэлийн хэлтэрхий гэх мэт зүйлс гарав. Уг хоёр булшийг тонуулчид тонохдоо талийгаачийн гавлын ясыг гарган хаясан байлаа.


Түүнчлэн Бурхан толгойн зүүн урд талын жижиг хөтлийг нутгийн иргэд Элст хөтөл хэмээх нэрлэх бөгөөд уг хөтлийн зүүн онь дээр жижиг хэмжээний чулуун дараастай булш байсныг малтан судлахад Түрэгийн үеийн оршуулга болох нь маллагын явцад илэрхий болсон билээ. Энэхүү оршуулгыг УБ-03 хэмээн дугаарлан малтав. Тус булшнаас үйсэн хоромсого, хүрэл чимэглэл бүхий агсарга бүстэй хүний оршуулга илэрсэн болно.

Монголын үеийн дурсгалууд


Манай хээрийн шинжилгээний анги Их хөтөл, Элст хөтөл зэрэг газруудад Монголын үед хамаарах 4 булшийг малтан судлав.

Их хөтлийн малтлага судалгаа. Харуулын гозгор уулын урд талын Эгийн голын зүүн эргийг дагасан өндөрлөг баруун талдаа ханан хясаа бүхий зүүн талдаа налуу энгэр газрыг Их хөтөл хэмээн нэрлэх ажээ. Энэхүү хөтлийн зүүн тал руу сунаж тогтсон жижиг үзүүрийн өвөр энгэрт мөн 1 жижиг хэмжээний чулуун дараастай цувраа 3 булш, ялимгүй зайтай 1 нийт 4 булш байсныг шалган малтан судлахад Монгол гүрний үед хамаарах нь тодорхой болов. Уг дурсгалуудыг малтан судлахад *Дурсгал-1*-ээс ямар нэгэн оршуулга, эд өлгийн зүйл, зан үйлийн ул мөр илрээгүй бол *Дурсгал-2*-оос үйсэн авсанд оршуулсан хүний бүтэн яс илрэв. Түүнчлэн *Дурсгал-3*-аас хүүхдийн бүтэн оршуулга илэрсэн бол *Дурсгал-4*-өөс мөн адил хүүхдийн оршуулга гарсан боловч тонуулчдын гарт өртөн анхны зохион байгуулалтаа ихэд алдсан байлаа.

Элст хөтлийн малтлага судалгаа. Бурхан толгойн зүүн урд талын Элст хөтөлд УБ-03 –аас зүүн хойш 30 м орчим зайд мөн жижиг хэмжээний чулуун дараастай булш байсныг шалган малтан судлахад Монгол гүрний үед холбогдох булш байв. Уг булшийг УБ-04 хэмээн дугаарлан малтлага судалгааны ажлыг гүйцэтгэхэд хүнээ үйсээр битүү ороосон, шагайт чөмөг, жижиг ясан эдлэл дагалдуулсан тоногдоогүй хүний оршуулга илэрсэн юм.



Монгол улс, Булган аймаг, Эгийн голын ерөнхий байршил



Элст хөтлийн УБ-03 –ын Түрэг булины дэвсгэр зураг



Элст хөтлийн УБ-03 –ын Түрэг бушины малтлагын ерөнхий байдал